

БУРГАСТАЙН БИЧИГТ ХАДНЫ БИЧЭЭС

Ц.Баттулга*

Баруун бүс нутаг, нэн ялангуяа Увс аймгийн нутаг дахь эртний түүх соёлын дурсгалыг бүс нутгийн хүрээнд цогц байдлаар судлах зорилгоор манай эрдэмтэд сүүлийн жилүүдэд үндэсний болон гадаадын судалгааны байгууллагатай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, түүний үр дүнд багагүй судалгаа хийсэн байна. Тэдгээрээс Увс аймгийн Давст сумын нутагт орших Бургастайн бичигт хадны зураг дурсгалыг хэд хэдэн хээрийн шинжилгээ, судалгааны анги үзэж судалсан ажээ. Тухайлбал, 2016 онд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнтэй хамтарч Увс аймгийн Давст, Сагил, Түргэн, Тариалан, Ховд, Өмнөговь сумдын нутагт хайгуул судалгаа хийсэн бөгөөд тус судалгааны ажлын хүрээнд Увс аймгийн Давст сумын нутгаас руни бичгийн нэг мөр бичээс илрүүлсэн тухай тэмдэглэсэн байдаг. Судлаачид тайландаа “Эл дурсгалт газар нь Увс аймгийн Давст сумын нутагт, Боршоо-Хандгайтын олон улсын хилийн боомтоос баруун зүгт 7 км зайд дархан хилийн тусгай бүсэд оршино. Хадны зургийн дурсгал нь уулархаг бүс нутагт орших бөгөөд томоохон уулсын нарийн хөндийд орших баруунаас зүүн зүгт хошуулдан цуварсан ойролцоогоор хагас километр урт үргэлжлэх хадархаг толгодыг нэлэнхүйд нь хамран оршино. Хадны зургийн дийлэнх нь хүрэл зэвсгийн сүүл үед хиргисүүр ба буган хөшөөний соёлт эртний ард түмний үлдээсэн дурсгал байх бүрэн боломжтой байна. Хос морь хөллөсөн хоёр дугуйтай байлдааны тэрэг, буган хөшөөнөө элбэг дүрслэгддэг бугын загварчилсан дүрслэл, тамга тэмдэг, ан амьтад болон аж байдал, ан агнуурын сэдэвтэй зохиомжит дүрслэлүүд элбэг тохиолдох ажээ. Мөн эдгээр дүрслэлээс гадна нэг мөр руни бичгийн дурсгал хадгалагдан үлдсэн байна (Зур. 7-9)” (Эрдэнэ-Очир; Килуновская, 2016: 15) гэж дурджээ.

2022 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн түрүү үеийн салбарын секторын эрхлэгч, доктор Н.Батболд, эрдэм шинжилгээний

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Ази судлалын тэнхимийн профессор, доктор (Ph.D).
tulga@num.edu.mn; battulgatsend976@gmail.com

ажилтан Д.Содномжамц, Б.Буян-Орших нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг Монгол-Германы хамтарсан MAPSS төслийн хүрээнд Увс аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны хүрээнд Бургастайн бичигт хадны зураг бичээс, тамга, булш дурсгалыг дахин шинээр бүртгэн баримтжуулсан байна. Тэдгээр судлаачид тайландаа “*Бургастайн бичигт (Бичигт хаяа) хадны зураг Бургаст уулнаас зүүн урагш чиглэсэн уужим хөндийг Бургастайн хөндий гэдэг. Бургастайн хөндийд баруун хойноос зүүн урагш чиглэсэн орой хэсгээрээ дэл хадтай жижиг толгодыг ерөнхийд нь Бургастайн бичигт хад хэмээн нэрлэдэг. Энэхүү дурсгалт газрын нэрийг анх академич Д.Цэвээндорж Бургастайн хөндийн Ганц Харгайтын бичигт хад, Т.Бямбадорж Бургастайн бичигт хад, доктор Н.Эрдэнэ-Очир Бичигт хаяа хэмээн гурван өөр нэрээр тэмдэглэсэн байна. Бид нутгийн иргэдийн мэдээллийн дагуу Бургастайн бичигт хад гэсэн нэрээр тэмдэглэж бүртгэн баримтжуулалтын ажил хийв. Бургастайн бичигт хадны үзүүр хэсэг нь хөх саарал өнгийн элсэн занар чулуун тогтоцтой бол орой хэсэг нь улаан шаргал өнгийн боржин чулуун хадтай. Ойролцоогоор хадны зурагтай нийт талбай 1,3 км урт үргэлжилнэ. Янгир, буга, адуу, үхэр, араатан зэрэг ан амьтдын зураг дийлэнх хэсгийг эзлэх бол ан хийж буй нум сумтай анчин болон зогсож буй хүний дүрслэл цөөн тоотой байна. Үүнээс гадна Бургастайн бичигт хадны дунд хэсэгт Түрэгийн руни бичээс болон тамга тэмдгийн дүрслэлтэй. Мөн дурсгалт газрын ойролцоо сагсай хэлбэрийн булш бий. Хадны зургийн дурсгалууд нь он цагийн хувьд хүрлийн хожуу үеэс Уйгурын үе хүртэлх хугацаанд хамаарна” (Баттулга, 2022: 8) хэмээн хадны зургаас гадна бичээс, тамга, булш дурсгалыг тухайлан нарийн нягт бүртгэн тэмдэглэжээ.*

Д.Содномжамц, Н.Батболд, Б.Буян-Орших нар “Монголын археологи-2022” эрдэм шинжилгээний хуралд “MAPSS” төслийн хүрээнд Увс аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын товч үр дүн” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн байх бөгөөд тус илтгэлдээ (Содномжамц ба бус, 2022: 305-308) руни бичээсийг дурдаагүй ажээ.

ОХУ-ын мэргэжил нэгт нөхдөөс 2016, 2017 оны үед уг бичээсийг уншиж судалсан эсэх талаар лавлаж байсан бөгөөд хожим тайлан уншиж судалгааны эргэлтэд оруулсан эсэхийг лавласан ч тодорхой хариу ирээгүй билээ. Бодвол, дахин ирж бичээсийг тухайлан судлахаар төлөвлөж байсан ч цар тахал болон бусад шалтгаанаар нягтлах боломж олдоогүй байж ч болох юм. Хэрвээ хэвлүүлсэн байваас бидний уншлага судалгаатай харьцуулж үзэх буй за. Учир нь уг бичээсийг ОХУ-ын судлаачдын уншлага судалгаа гарсны дараа хэвлүүлнэ гэж хүлээнээс нэг хэсэг мартагдаж, өөрийн судалгааны бүтээлд (Баттулга, 2021: 144-160) ч оруулаагүй билээ. Эс хэвлүүлбэл дахиад хэдэн жил ч улиран өнгөрч мэдэх тул судалгааг толилуулахаар зорьсон болно.

“Бургастайн бичигт хад” хэмээх нэрийн талаар цухас тэмдэглэх нь

Монголын руни бичгийн нэгэн өвөрмөц шинэ дурсгал оршиж буй уг газрын нэрийг эрдэмтэд өөр өөрөөр тэмдэглэжээ. Үүнд:

1. Академич Д.Цэвээндорж “Бургастайн хөндийн Ганц Харгайтын бичигт хад”;
2. Увс аймгийн музейн захирал асан Т.Бямбадорж “Бургастайн бичигт хад”;
3. Н.Эрдэнэ-Очир, М.Е.Килуновская нар “Бичигт хаяа”;
4. Н.Батболд, Д.Содномжамц, Б.Буян-Орших нар “Бургастайн бичигт хад” хэмээн тэмдэглэж өөр өөрсдийн тайландаа дурдсан байна.

Тухайн дурсгалт газрыг өөр өөр нэрлэснээс үүдэж, хожим эндүүрэл гарч, төөрч будилах болуузай хэмээн сэрэмжилж газрын нэрийг тодорхой болгохыг хичээлээ. Нутаг орныхоо түүх соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх үйлсэд насан турш зүтгэсэн аймгийн музейн захирал асан Т.Бямбадорж гуай “Бургастайн бичигт хад” гэж тэмдэглэсэн бол археологич Н.Батболд, Д.Содномжамц, Б.Буян-Орших нар “... нутгийн иргэдийн мэдээллийн дагуу Бургастайн бичигт хад гэсэн нэрээр тэмдэглэж бүртгэн баримтжуулсан” тухайгаа дурдсан байна.

Дээрх хоёр баримтаас гадна хилийн албан хаагчид уг дурсгалт газрыг бидэнд “Бургастайн бичигт хад” гэж албан ёсоор нэрлэдэг болохыг хэлсэн билээ. Тиймээс энэхүү руни бичгийн дурсгалыг “Бургастайн бичигт хадны бичээс” хэмээн нэрлэх нь зүйд нийцнэ хэмээн үзэв. Бургастайн уулыг бэллэн баруун хойноос зүүн урагш чиглэж тогтсон урт гүвээ хамар байх бөгөөд гүвээ хамрын үзүүр, адгаас хадны зураг дурсгал эхлэх ажээ. Уг гүвээ хамрын хянга дагасан дэл хаданд хүрэл зэвсгийн үед ихэвчлэн холбогдох зураг элбэг байх бөгөөд зурсан аргын хувьд бусад хадны зургийн адил нийтлэг шинжтэй байна. Тус гүвээ хамрын эх орчимд, баруун өмнө зүг хандсан намхан энгэрт хоёр мөр руни бичээс, тамга, хадны зураг бүхий хавтгай хад байх бөгөөд хадны өнгөн хэсгийг холцруулан цохих аргаар хоёр мөр бичээс бичжээ. Бичээсний хэв дардас авахад эхний мөр тун бүдэг бадаг, хоёрдугаар мөр харагдахуйц гарсан нь нэгдүгээр мөрийг өнгөц, харин хоёрдугаар мөрийг харьцангуй гүн цохиж бичсэнтэй холбоотой болно.

Бичээсний нэгдүгээр мөрийн урт 32 см, үсгийн өндөр ~ 5 см, зургаан үсэг тэмдэгтээс, хоёрдугаар мөрийн урт 92 см, үсгийн өндөр ~15-8 см, арван үсэг тэмдэгтээс тус тус бүрдэж байна. Сайн ажиглавал, хоёрдугаар мөрийн төгсгөлийн үсэг тэмдэгт бүхий хэсэг эрт үед хугарч, улмаар холцрон унасан болох нь хадны хагархайгаас тодорхой харагдана. Тиймээс хоёрдугаар мөрийг 11 үсэг тэмдэгтээс бүрдэж байжээ хэмээн үзэв. Бичээсний үсэг тэмдэгтийг томоор бичиж эхэлсэн боловч бичих явцад жижгэрсээр төгссөн байна. Бичээсний доор мохоо өнцөгт нэг тамгыг томоор, маш тодорхой

сийлжээ. Тус мохоо өнцөгт тамгын баруун тал 27 см, зүүн тал 37 см бөгөөд бичээст шууд холбогдох тамга болох нь тодорхой.

Бичээс бүхий хадан дээрх дүрслэлийг тодорхойлбол, хадны дээд хэсэгт өндөр биетэй хүн том нумаар харваж буйг маш тодорхой дүрсэлжээ. Нумаа хүчтэй татаж, сум тавьсан нь гараа алдалж, арагш сунгасан байдалтай дүрсэлснээс илэрхий байх бөгөөд сум нумаас хараахан бүрэн гараагүй байгаа ч дүрслэн харуулжээ. Түүний доор зүүн зүг харсан сүрлэг эвэртэй, урт хүзүүтэй янгир дүрсэлсэн байна. Янгирыг өндөр, урт хүзүүтэй дүрсэлсэн нь сүрлэг сайхныг илтгэсэн үү, эсвэл үргэж сэрэмжлээд хүзүү сунган харж буйг дүрсэлсэн үү гэдгийг мэдэж, ялган тогтоох боломжгүй юм. Янгирын ард нохой адил эргэсэн бус модон сүүлтэй, босоо чихтэй чоно бололтой амьтны болхидуу дүрс зураг байх ба хэрвээ хоёр зургийг нэг үеийнх гэж үзвэл, нас бие гүйцсэн, сүрлэг том янгирын тэхийг гуринхалсан туранхай, эс бөгөөс бага залуу чоно гэтэж, хөөхөөр завдаж буйг дүрсэлжээ гэж үзэж болохуйц ажээ. Тэрхүү сүрлэг эвэр, урт хүзүүт янгир, чоно бололтой амьтны доор зүүн зүг явж буй байдалтай нэжгээд янгир, бас хэдэн амьтны зураг бий. Эдгээр зургийн доор сүүлээ сөхсөн, сэлмэн эвэрт янгирыг зүүн хойш чиглүүлж, маш тодорхой дүрсэлсэн байх бөгөөд уг янгирын эврийн төгсгөлөөс залгуулж бичээсний хоёрдугаар мөрийг эхлүүлэн бичсэн байна. Бичээсний хоёрдугаар мөрийн 6-р тэмдэгтийн харалдаа доор урт, босоо эвэрт янгирыг баруун зүг хандан зогсож буй байдалтай дүрсэлжээ. Босоо эвэртэй, зэгзгэр, урт хөлтэй зурсан нь магадгүй гунан, дөнөн настай залуу янгир болохыг илтгэсэн бололтой. Түүний доор мохоо өнцөгт тамгыг харьцангуй томоор, тун тод сийлсэн нь бичээст шууд холбогдох тамга болохыг бид дээр дурдсан билээ. Тус тамганы харалдаа зүүн талд баруун зүг харсан янгир, түүний доор зүүн хойш чиглүүлж, бас нэг янгирыг тус тус дүрсэлжээ.

Нэг хавтгайд буюу бичээс бүхий хаданд зурсан зургууд тодорхой дэс дараалалгүй (системгүй), янгирыг өөр өөр зүг хандуулсан байдлаас ажиглахад хадны зургууд он цагийн хувьд хүрэл зэвсгийн үед холбогдох нэг цаг үеийн зураг мөн боловч зүүн дээд талын хэсэг зургаас бусад нь ихэвчлэн хам сэдвийн хүрээнд зурагдаагүй, уван цуван зурагдсан зургууд болох нь илэрхий байна.

Бургастайн бичигт хаданд тэмээ дүрсэлсэн зураг харьцангуй их байх бөгөөд унасан, хөтөлсөн, ачаа ачсан тэдгээр зургууд тэмээг уналга, ачлагад өргөн ашигласны үр дүнд аж ахуй хийгээд өдөр тутмын амьдралд ихээхэн нөлөө үзүүлсэн тэр түүхэн цаг үеийн бодит баримт, сурвалж болохын хувьд чухал ач холбогдолтойг онцлон дурдъя.

Хадны зураг, бичээс, тамга бүхий хавтгай хад налуу байрлалтай тул бороо, цасны ус үргэлж тунарч тогтон шингэдгээс хадны доод хэсгээр улаан, цайвар, шар өнгийн хаг нягт, зүүн доод, зүүн дээд хэсгээр харьцангуй

сийрэг ургаж зарим зургийг хагас, зарим зургийг бүрэн дарж харагдахгүй болгожээ. Бичээсний хоёрдугаар мөрийн эхний хоёр үсэг тэмдэгтийг бичсэн хэв ормыг дагаж, хадны хаг ургаж эхэлсэн нь хожим нэмэгдэж, бичээс бүрхэгдэж болзошгүй байна. Хадны хагаас гадна руни бичээс, тамга, зураг бүхий тус хадны баруун талаас ойролцоогоор 20 орчим см хэсэг эрт үед хугарч, улмаар ховхрон унасан нь хадны хагархайнаас анзаарагдах бөгөөд уг хадны баруун доод булангаас жижигхэн хэсэг эмтэрч унахад нэгэнт бэлэн болсон харагдана.

Бургастайн бичигтийн хад нэлэнхийдээ насжиж, өгөршсөнөөс гадна он цагийн уртад нар салхи, цас борооны ус, эрс тэс уур амьсгал зэрэг байгалийн нөлөөгөөр жил ирэх тутам холцорч унах, эмтэрч хэлтрэх эрсдэл нэмэгдэх хандлага илэрхий ажиглагдаж байна. Тиймээс тус дурсгалыг авран хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалан хамгаалах, сэргээн засварлахад холбогдох хууль журмын хүрээнд зөөж, музейд тавих, эсвээс хэв дардас авч хадгалах ажлыг тун яаралтай хийх шаардлагатайг онцлон тэмдэглэе.

Бургастайн бичигт хадны руни бичээсний судалгаа

Бургастайн бичигт хадны руни бичээсний үсэг тэмдэгт нэн тодорхой, уншиж судлахад бэрхшээлгүй боловч төгсгөлийн үсэгт тэмдэгт эрт үед хугарч унасан хагархайд байсан нь гарцаагүй байна. Үлдсэн ормоор баримжаалбал хугархай ойролцоогоор 20 см орчим өргөн байсан нь нэг үсэг тэмдэгт багтахуйц хэмжээ юм. Тиймээс бичээсний өгүүлбэрийн хэл зүйн хувиргалд түшиглэн h η үсэг тэмдэг байх боломжтой хэмээн сэргээв.

Бичээсний эхийн сийрүүлгэ:

ገጽ 1

[4] 77: 2

Үсгийн галиг:

1. ɳ ɔ ɾ ʁ ɛ ɾ
2. ɳ ɥ ʃ ʊ ʒ ʒ ɔ : k ü r[ün]

Үгийн галиг:

1. qanī bāgi
2. qara bodun[i] kör[ün]

Үгчилсэн орчуулга:

1. хан нь, ноён нь
2. харц ард иргэд [нь] үз[эгтүн]

Бичээсийг “Хан нь, ноён нь, харц ард иргэд нь мэдэгтүн” хэмээн утгачлан орчуулж болох бөгөөд агуулгаас үзвэл аян дайнд ялсан, эсвээс тухайн үеийн энэ газар нутагт оршин амьдарч байсан овог аймаг, ханлигуудыг эрхшээлдээ оруулж, нэгтгэсэн үйл явдалтай холбоотойгоор

ялсан цэргийн жанжин, эрх мэдэлт, өндөр албан тушаалтан ялагдсан буюу эрхшээгдсэн овог аймаг, ханлигийн хан, ноён, харц ард иргэдэд хандаж гаргасан зарлиг, захирамжийг сануулсан бичиг үйлдүүлсэн бололтой.

Бургастайн бичигт хадны бичээсний e b , $\dot{E}$ B үсэг, тусгаарлах $\wedge$ хос зураас зэрэг өвөрмөц бичлэг Монголын руни бичгийн дурсгалд тун цөөн тохиолдох бөгөөд орон нутгийн онцлог хэв шинжит үсэг зүйн тигтэй дурсгал гэдгээрээ эрс ялгарч байна.

Монголын руни бичгийн сонгодог дурсгалд $\mathcal{Q}\mathcal{H}$ *qayan* - хаан цол олон, харин $\mathcal{Q}\mathcal{H}$ *qan* – хан цол харьцангуй цөөн тэмдэглэгдсэн байдаг. Утгын хувьд эрс ялгарах ялгаа, их бага дэсийг илэрхийлжээ гэж үзэх баримт нотолгоо хомс бөгөөд зарим бичээст нэг хааны түүхэн хэрэг явдлыг тэмдэглэхдээ $\mathcal{Q}\mathcal{H}$ *qayan* –хаан, $\mathcal{Q}\mathcal{H}$ *qan* – хан гэж хольж бичсэн ч буй билээ. Монголын руни бичгийн бага дурсгалд nK *qan* гэдэг үг төвийн бүс нутгаас илэрсэн руни хэд хэдэн дурсгалд тохиолдоно. Харин баруун бүс нутгаас анх удаа $\mathcal{Q}\mathcal{H}$ *qan* гэх үг бүхий хадны бичээс илэрч буй нь Бургастайн бичигт хадны эл бичээс юм. Бичээст өвөрмөц содон үг хэллэг байхгүй боловч эртний түрэг хэлний үгийн сан шинэ сурвалжийн мэдээгээр улам баяжин нэмэгдэж буйд уг дурсгалын үнэ цэн, ач холбогдол оршиж байна.

Бургастайн бичигт хадны бичээсний үгийн тухайд:

$\mathcal{Q}\mathcal{H}$ *qanī* -хан нь. $\mathcal{Q}\mathcal{H} < \mathcal{Q}\mathcal{H}-\mathcal{I}$ *qan* - i (гуравдугаар биед хамаатуулах нөхцөл) $\mathcal{I}\mathcal{E}\mathcal{X}$ *bägi* – ноён нь. $\mathcal{I}\mathcal{E}\mathcal{X}$ *bägi* $< \mathcal{E}\mathcal{X}$ - $\mathcal{I}i$ *bäg* - i (гуравдугаар биед хамаатуулах нөхцөл)

$\mathcal{Q}\mathcal{X}\mathcal{Q}\mathcal{Q}\mathcal{H}\mathcal{H}$ *qara bodun* – харц ард, харц ард иргэд. $\mathcal{Q}\mathcal{X}\mathcal{Q}\mathcal{Q}\mathcal{H}\mathcal{H}$ *qara bodun* $< \mathcal{Q}\mathcal{X}\mathcal{Q}\mathcal{Q}\mathcal{H}\mathcal{H}$ *qara bodun*- $\emptyset$ гэж III биед хамаатуулах нөхцөл тэг хувилбараар илэрчээ гэж үзэв.

$[\mathcal{Y}]\mathcal{Y}\mathcal{H}\mathcal{Y}$ *kör[üŋ]*- үзэгтүн. $[\mathcal{Y}]\mathcal{Y}\mathcal{H}\mathcal{Y} < \mathcal{Y}\mathcal{H}\mathcal{Y}$ *kör* - η . *kör* нь үз-, хар- гэх идэвхтэй үйл язгуур.

- η хоёрдугаар бие, захиран хүсэх нөхцөл. Хэдийгээр үгийн язгуур *kör* – η буюу үз-, хар, үзэгтүн, харагтун мөн боловч утга нь уншигтун, мэдэгтүн хэмээсэн нь тодорхой юм.

Төв Азийн өндөрлөгт төр улсаа байгуулан мандаж асан Түрэг, Уйгурын хаант улсын нийгмийн гол давхаргыг *ndov bodun*- ард, иргэд, ард иргэд гэдэг. Харин $\mathcal{Q}\mathcal{X}\mathcal{Q}\mathcal{Q}\mathcal{H}\mathcal{H}$ *qara bodun*-, үгчилбэл хар ард, хар иргэд, хар ард иргэд буюу харц ард, харц ард иргэд гэдэг нь тухайн овог аймгийн үндсэн хүн амыг зааж тодорхойлсон, алба татвар төлөх, цэрэг, уналга гаргах чадвартай албат ард буюу гол цом ард иргэдийг ялган тэмдэглэсэн үг хэллэг юм.

Монгол нутаг дахь Түрэгийн үеийн руни бичгийн сонгодог дурсгалаас Күл тигиний гэрэлт хөшөөний зүүн талын 8-9, 38, 39, 40-р мөр, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 8, 29, 41-р мөр, Онгийн гэрэлт хөшөөний 9-р мөрд *𐰽𐰺𐰍𐰏 qara bodun* гэж тус тус тэмдэглэгджээ. Харин Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалаас Шинэ ус (Баян/Моюн чур)-ны гэрэлт хөшөөний хойд талын 12-р мөр, зүүн талын 2, 5-р мөр, Тариатын гэрэлт хөшөөний өмнө талын 4, 5, 6 дугаар мөрүүдэд уг үг хэллэг дурдагдсан байдаг. Монголын руни бичгийн бага дурсгалуудад *𐰽𐰺𐰍𐰏 qara bodun*- харц ард, харц ард иргэд гэх үг огт тохиолдож байсангүй, одоогоор Бургастайн бичигт хадны эл бичээс уг үг бүхий хамгийн анхны дурсгалд зүй ёсоор тооцогдож байна.

Енисейн дурсгалуудаас, Тувагийн нутагт байх Уюук Туран (E3/6)-ны бичээст нэг удаа, Элэгэст (E10/7, 12)-ийн бичээст хоёр удаа *𐰽𐰺𐰍𐰏 qara bodun*- харц ард, харц ард иргэд гэж тэмдэглэгдсэн (Кормушин, 2008: 189-192; 228-237) байх бөгөөд Монгол улсын, ОХУ-ын Тува улстай хиллэх хилийн шугамд хамаарах газар нутагт мөн л *𐰽𐰺𐰍𐰏 qara bodun*- харц ард, харц ард иргэд гэх үг бүхий бичээс олдож байгаа нь тохиолдол бус, ард иргэдийн аман яриа, алба бичгийн зүйлд бичиж тэмдэглэж нэгэнт хэвшсэн байсан тухайн үеийн нийгмийн хамгийн өргөн, түгээмэл хэрэглээтэй үг байсны илрэл юм.

Энэ далимд тэмдэглэхэд, Монгол улс болон ОХУ-ын Тува улсын нутаг дэвсгэрээс илэрсэн *𐰽𐰺𐰍𐰏 qara bodun*- харц ард, харц ард иргэд гэх үг хэллэг бүхий бичээст шууд холбогдох тамга өөр өөр байгаа нь тэдгээр бичээс нэг овог аймагт хамаарах, эсвээс нэг жанжин, эрх тушаалтны бичүүлсэн бичээс байх боломжгүй болохыг нотлон харуулж байна. Харин тухайн үеийн нийгмийн хамгийн түгээмэл хэрэглээтэй үг хэллэг хэрэглэснээс үзэхэд, он цагийн хувьд тун ойролцоо нэг үед бичигдсэн байх боломжтой юм.

Түрэг, Уйгурын хаант улсын нийгмийн гол гурван давхаргад хандаж бичсэнд Бургастайн бичигт хадны бичээсний гол онцлог оршиж байна. Үүнд,

𐰽 qan - хан - төр улс, ханлиг, овог аймгийг захирагч дээд давхарга.

ᠡᠯ bāg - ноён - төр, улсын хэргийг гүйцэтгэгч, төрийн албатан дунд давхарга.

𐰽𐰺𐰍𐰏 qara bodun - харц ард, харц иргэд, харц ард иргэд.

Хаант төр, харьяат ханлиг, аймаг, овгийн үндсэн цөм ард иргэд мөн бөгөөд бэг ноёдод захирагдах доод давхарга. Нийгмийн дээрх давхарга бүрд хамаатуулж “Хандсан бичээс” бичүүлсэн нь тухайн үеийн нийгэм улс төрд нөлөөлөхүйц томоохон үйл явдалд биечлэн оролцож, тэрхүү үйл явдлыг амжилттай шийдвэрлээд тус бүс нутагт байсан овог аймгийг

эрхшээлдээ оруулж, бослого хөдөлгөөн, дайн самууныг дарж, эмхлэн журамлаад, дагаж мөрдөх зарлиг, тушаал буулгаж, түүнийг цаг ямагт хан, ноён, харц ард ялгалгүй бүгдээр сахиж явахыг сануулах зорилго агуулсан байж болох юм.

Алтайн уулс давж нэвтрэх эртний улбаатай хоёр гол зам өдгөө Монгол улс, ОХУ-ын хилийн боомт болжээ. Эдгээр замын эхнийх нь Увс аймгийн Давст сумын Боршоо - Хандгайтын боомт зам, нөгөө нь Баян-Өлгий аймгийн Цагааннуур сумын Улаан Байшинт - Хоч Агачийн боомт юм. Улаан Байшинтын боомтоос холгүй, хилийн цаана ОХУ-ын Бүгд Найрамдах Алтай улсын нутаг Хоч Агачийн боомтоос руни бичгийн дурсгал илэрч уншиж судалсан¹ байдаг. Алтайн уулс давах хоёр гол зам болох Боршоо - Хандгайтын боомт, Улаан Байшинт - Хоч Агачийн боомтоос илэрсэн руни бичгийн эдгээр дурсгалууд эртний төрт улсуудын арилжаа худалдаа, алба хэрэг, аян дайны замыг тодруулах, холбогдох түүхэн хэрэг явдлыг тодлон судлахад чухал ач холбогдолтой түүхэн сурвалж болох нь дамжиггүй бөгөөд үүнд тус руни бичгийн дурсгалын үнэ цэн оршиж байна.

Эртний төрт улс хийгээд овог аймгуудын харилцаанд, түүхийн олон үеийн туршид чухал үүрэг гүйцэтгэсэн эдгээр зам одоо үед ч хоёр улсын төдийгүй олон улсын харилцаа, тухайлан худалдаа, зам тээврийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа билээ.

Тамга

Тамганы тухайд уг бичээсийг бичүүлэгчийн тамга уу, эсвэл бичээс бичсэн бичээчийн тамга уу гэдгийг шууд хэлэхэд бэрхтэй. Гэхдээ цор ганц тамга байгаагаас үзвэл, хэргэм зэрэгтний тушаал, захирамжаар бичээс бичиж, бичүүлэгч этгээдийн овог аймгийнхаа тамгыг мөн сийлсэн байх магадлал тун их болно. Учир нь хан, ноён, ардад хандсан бичээс бичүүлж буй этгээд өөрөө бичээгүй, бичээчээр бичүүлсэн нь лавтай.

Монголын руни бичгийн дурсгалд шууд болон дам холбогдох тамгыг сийлж, цохисон үлдээсэн баримт, байр, дарааллаас ажиглахад дуртган бичүүлэгчийн тамга эхэнд, бичээчийн тамга удаалж, оролцогчдын тамга овог аймгийн байр суурь, хэргэм зэрэг, алба тушаалаас хамаарч харилцан адилгүй байрлалтай байх түгээмэл зүй тогтолтой болох нь ажиглагддаг.

Төрт улсын төв нутгаас зайдуу, алс хязгаар нутагт “Хан нь, ноён нь, хамаг харц ард иргэд нь уншиж мэдэгтүн” гэсэн утга агуулга бүхий бичээс бичиж үлдээснээс үзвэл, ялгуусан их ялалт байгуулсан цэргийн жанжин зэрэг өндөр хэргэм зэрэг, албан тушаалтан бичээсийг бичүүлж, өөрийн

¹ Тыбыкова Л.Н., Невская И.А., Эрдал М, Каталог древнетюркских рунических памятников Горного Алтая. Горно – Алтайск, 2012.

овог аймгийн тамгаа сийлүүлжээ гэж үзэх үндэслэлтэй. Уг тамга аль, ямар овог аймгийн тамга болох талаар судлаачдын зарим нэг санал, таамаг буй боловч баттай бус, бидний санал ч нийлэхгүй тул энэ удаад бичээс, тамга сийлүүлсэн этгээдийн овог аймгийн тухайд дурдахыг түр түдгэлзэв.

Талархал

Энэхүү бичээсийг үзэж судлахад хамтран ажилласан Увс аймгийн музейн захирал Ш.Цэдэнбал, сан хөмрөгч О.Мянганбуу, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гэрээт ажилтан Б.Буян-Орших, МУИС-ийн Түрэг судлалын салбарын докторант Лха.Батбилэг, Б.Энэрэл нарт талархал илэрхийлж, ажил үйлс, эрдэм судлалын их их амжилт хүсэн ерөөе.

Ном зүй

Батболд Н., Содномжамц Д., Буян-Орших Б. (2022). *Монгол-Германы хамтарсан MAPSS төслийн хүрээнд Увс аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны тайлан*. Улаанбаатар.

Баттулга, Ц. (2020). *Монголын руни бичгийн бага дурсгал*. Монголын Археологийн өв. XII боть. Улаанбаатар.

Баттулга, Ц. (2021). *Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа*. I боть. Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. Улаанбаатар.

Кормушин, И.В. (2008). *Тюркские Енисейские Эпитафии (Грамматика Текстология)*. Москва.

Содномжамц Д., Батболд, Н., Буян-Орших Б. (2022). “*Mapss*” төслийн хүрээнд Увс аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын товч үр дүн. Монголын археологи 2022. Улаанбаатар.

Тыбыкова Л.Н., Невская И.А., Эрдал М. (2012). *Каталог древнетюркских рунических памятников Горного Алтая*. Горно – Алтайск.

Цэвээндорж, Д. (1982). *1982 онд Увс, Хөвсгөл, Завхан аймагт ажилласан нүүдэлчдийн дурсгал судлах ангийн тайлан*. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. Улаанбаатар.

Цэвээндорж Д., Энхбат Б. (1989). *Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний ангийн тайлан*. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. Улаанбаатар.

Цэвээндорж, Д. (1999). *Монголын эртний урлагийн түүх*. Улаанбаатар.

Эрдэнэ-Очир Н., Килуновская М.Е. (2016). *Увс аймгийн Давст сумын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны тайлан*. ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. (Монгол - Оросын хамтарсан хээрийн шинжилгээний анги). Улаанбаатар.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.

Хавсралт



Бургастайн бичигтийн бичээс бүхий хадны ерөнхий байдал



Бургастайн бичигт хадны бичээс